

1.8 КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ТАЛААР

Компанийн дүрмийн 6 дугаар зүйлд зааснаар энгийн хувьцаа эзэмшигчид нь дараах эрхтэй байна.

Компанийн энгийн хувьцаа худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.

Компанийг татан буулгах үед компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.

Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

- Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх.
- Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25%-иас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компани урьд гаргасан энгийн хувьцааны 25%-иас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэрэг их хэмжээний хэлцэл хийсэн.
- Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ гишүүн, эсхүл гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх эрхтэй.

Хувьцаа эзэмшигч нь “Компанийн тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 4-д заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.

Компанийн энгийн хувьцааны нэг болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтны буруугаар компани болон өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитийн шалгалт хийлгэх эрхтэй.

Хувь нийлүүлэгч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Ногдол ашиг хуваарилах нөхцөл

Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх.

Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх.

Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ үүний шалтгааныг хувь нийлүүлэгчдийн хуралд тайлагнана.

Ногдол ашиг хуваариласны дараа үлдэх ашгаас нийгэм соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Сан байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар баталж мөрдөнө.

ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах эрхтэй.

Компанийн дүрэм хавтаст материалын хуудсанд